



**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Д.ҮҮРИЙНТУЯА ТАНАА

2016.02.25 № 3/240

таний -ны № -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ашигт малтмалын газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланда аудит хийв.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Ашигт малтмалын газрын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Ашигт малтмалын газрын удирдлага 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйслийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХЗАЯА

УХА0122

W:\10.10.10.20\Bichig\_Khereg\Yawsan\_Bichig\2016\0225SAG14.Docx

071374



## АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗРЫН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:

ТАБ-ын Тэргуулэх аудитор  
С.Энхзаяа  
Утас: 261663  
Цахим хаяг: [enkhzayas@audit.gov.mn](mailto:enkhzayas@audit.gov.mn)

Аудитын менежер: Г.Гүнжидмаа  
Утас: 261885  
Цахим хаяг:  
[gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)

Шинжээч: Б.Энхжин  
Утас: 261780  
Цахим хаяг: [enkhjinb@audit.gov.mn](mailto:enkhjinb@audit.gov.mn)

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын  
газар  
Байршил: Чингэлтэй дүүрэг  
Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

2016 оны 2 дугаар сар

### Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

## АГУУЛГА

---

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланда хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж

**Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:**

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Ашигт малмалын газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд САГ-2016/1/СТА-ТШЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Ашигт малмалын газрын 2015 оны санхүүгийн тайлан Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бodoх бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бodoх бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бodoх бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, нягтлан бodoх бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Ашигт малмалын газрын 2015 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2015 оны 2 дугаар сарын 1-нээс 2015 оны 2 дугаар сарын 15-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын засгийн газрын нэгдсэн тайлангийн албаны шинжээч Б.Энхжин хэрэгжүүлэв.

Ашигт малмалын газрын 2015 оны санхүүгийн тайланг 2016 оны 1 дүгээр сарын 23-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2016 оны 1 дүгээр сарын 25-наас 2015 оны 2 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг хуульд заасан цаглабарын хугацаанд Ашигт малмалын газрын удирдлагад гардуулна.

**Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

Ашигт малтмалын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бodoх бүртгэлийн тухай, Монгол Улсын төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бodoх бүртгэлийн олон улсын стандарт

/УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдех нягтлан бodoх бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маят, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”ыг ашиглаж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуульд өөрчлөлт ороогүй боловч салбарын гол хууль болох ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт орж, түүнийг сурталчилах, олон нийтэд түгээх үйл ажиллагаа эрчимтэй явагдсан байна.

**Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:**

Ашиг малтмалын газрын эрхэм зорилго нь төрөөс геологи, уул уурхайн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулагчид, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай, шударга үйлчилгээ үзүүлэх, төрийн бодлогын удирдамжийг нь хэрэгжүүлэх замаар үндэсний эдийн засгийн хөгжилд эрдэс баялгийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд оршино.

Ашигт малтмалын газрын үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Ашигт малтмалын тухай хууль, Газрын хэвллийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх журам, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Уул уурхайн сайд, дэд сайдын бодлогын удирдамжийг хэрэгжүүлэхэд оршино.

Ашигт малтмалын газар нь эрхэм зорилгынхoo хүрээнд дараах үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Эрдэс баялгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад геологийн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах, бодлогын удирдамжийг нь хэрэгжүүлэх, энэ салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бүх талын таатай орчинг бүрдүүлэх;
- Эрдэс баялаг асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад геологи, уул уурхайн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах, бодлогын удирдамжийг нь хэрэгжүүлэх, энэ салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бүх талын таатай орчинг бүрдүүлэх;
- Ашигт малтмалын хуулийг хэрэгжүүлэх зорилгоор ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйлчилгээ үзүүлэх;;
- Төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн удирдлагаар хангах;

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр

ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “агентлагын дарга тус агентлагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу тус байгууллагын дарга Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Тухайн байгууллагын төсвийн 2015 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

**Дөрөв.Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Няглан бodoх бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Няглан бodoх бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Ашигт малтмалын газрын 2015 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансадад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Тухайн байгууллагын няглан бodoх бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Ашигт малтмалын газар нь санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх няглан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан АМГ-ын даргын 2014 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн а-2 дугаартай эрх зүйн актаар баталгаажуулан мөрдөж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, няглан бodoх бүртгэлийн програм нийцсэн байна.

Ашигт малтмалын газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Ашигт малтмалын газрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн Unicus програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Тухайн байгууллагын нийт орлогын 94.4 хувийг улсын төсөвт төвлөрүүлэх орлого эзэлж байна. Иймээс нийт хөрөнгийн 2 хувь буюу 56.8 сая төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тооцох нь зохимжтой гэж үзлээ.

**Тав. Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Ашигт малтмалын газрын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

**Зургаа. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**

2015 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

**Төсвийн гүйцэтгэлийн талаар**

Улсын төсвийн тухай хуулиар 2015 оны төсвийн тодотголоор 3,108.8 сая төгрөгийн ургал зардал батлагдснаас 2,856.0 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон бөгөөд гүйцэтгэлээр 2,800.0 сая төгрөгийн зарцуулалттай гарч төсөвт зардлыг 9.9 хувиар буюу 308.8 сая төгрөгөөр хэмнэжээ. Сангийн яамнаас тавигдсан санхүүжилтийн эрхийг 2.0 хувиар буюу 55.9 сая төгрөг хэмнэж улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

**Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын талаар.**

Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2008 оны 64 дүгээр тогтоолоор үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, төсвийн болон үйлчилгээний орлогыг улсын төсөвт бүрэн төвлөрүүлэхээр заасны дагуу 2015 онд 47,011.3 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө батлагдсан боловч төсвийн тодотголоор 42,963.5 сая төгрөг болгон бууруулсан бөгөөд Монгол Улсын төсвийн орлогыг цаг хугацаанд нь төвлөрүүлэн тайлант хугацаанд төсөвт нийтдээ 49,558.5 сая төгрөгийн орлого оруулсан нь батлагдсан төсвийг 115.3 хувиар давуулан биелүүлж ажилласан байна.

**Долоо. Шилэн дансны мэдээлэл.**

Ашигт малтмалын газар нь Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган 2014 оны 12-р сарын 25-ны өдөр [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд [900018003@gov.mn](mailto:900018003@gov.mn) хаягаар нэвтрэх эрх авч 2015 оны 1 дүгээр сарын 2-ны өдрөөс

Шилэн дансны хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасны дагуу байгууллагын цахим хуудас болох [www.mram.gov.mn](http://www.mram.gov.mn), шилэн дансны нэгдсэн цахим хуудас [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn)-д тус тус холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд нь тогтмол оруулан Уул уурхайн яамны ХШУДАГ-т улирал бүр тайлагнан ажиллаж байна.

**Найм. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдлүүдийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрт нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

**Ес. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:**

Ашигт малтмалын газрын 2015 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланда нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бусад орлого, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, гадаад томилолт, дотоод томилолт зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

**Арав. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:**

Аудитын явцад материаллаг хэмжээний алдаа илрээгүй. Харин материаллаг бус дараах зөрчил илэрснийг АМГ-ын удирдлагуудтай зөвшилцэн санал солилцсон болно. Үүнд:

1. Ашигт малтмалын газар нь 2015 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаар батлагдсан төсвийг нийт 308.8 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан боловч урсгал засварын зардлыг 1.4 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

**Шийдвэрлэсэн:** Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг баримтлан ажиллах.

2. 2015 оны төсвийн төслийг боловсруулахдаа улирал бүр олгох үр дүнгийн урамшууллыг цалингийн сангийн нэмэгдэл цалингаар төлөвлөж тайлант онд 116.6 сая төгрөгийн үр дүнгийн урамшууллыг нэмэгдэл цалингаас олгосон байна.

**Шийдвэрлэсэн:** Сангийн сайдын 2014 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 5 дугаар тушаалын 6 дугаар хавсралтыг баримтлан урамшууллын зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах.

**Арван нэг. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**

Залруулагдах боломжгүй алдаа байхгүй.

**Арван хоёр. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

**Арван гурав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Төсвийн шууд захирагч тухайн жилийн шаардлагдах санхүүжилтийн хэрэгцээ, төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан эсэх, дээр дурьдсан үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан эсэх, санхүүгийн бүртгэл, тайлагнал үнэн зөв бэлтгэгдсэн эсэхийг шалгахад анхаарлаа хандуулна.

**Арван дөрөв. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

Ашигт малтмалын газрын 2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 118 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд зөвлөмж өгөв.

**Арван тав. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

Төсвийн захирагчийн төсвийн 2014 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар 2 зөвлөмж өгсөн ба тэдгээрийн биелэлт дараах байдалтай байна.

1. Кигам төслийн гэрээний хэрэгжилтийг хангахад анхаарч Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн гэрээний дагуу ажиллаж байна.
2. Төсвийн хөрөнгийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан зайлшгүй шаардлагатай зарим бараа материалыг жилийн эцэст нөөцлөн оны эхэнд байгууллагын хэвийн үйл ажиллагааг /геологийн архив, тайлан төлөвлөгөө хүлээн авч хянах/ тасралтгүй явуулахад зарцуулсан. 2015 оны ургал зардлын төсөвт шатахуун болон бичиг хэргийн зардал хасагдаж батлагдсан бөгөөд Сангийн яамнаас төсвийн хуваарыт зардлыг бууруулан олгож байна. Бараа материалыг зохистой хэмжээгээр бэлтгэн зарцуулахад анхааран ажиллаж байна.

**Арван зургаа. Зөрчилгүй санал дүгнэлт**

Ашигт малтмалын газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн, шударга илэрхийлэгдсэн байна.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР  
БЭЛТГЭСЭН:  
ШИНЖЭЭЧ

  
  


С.ЭНХЗАЯА  
Г.ГҮНЖИДМАА  
Б.ЭНХЖИН

2016.2.25



## АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗРЫН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### Менежментийн захидал

Асуудал 1	
Зардал .....	12
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	14-21

2016 оны 2 дугаар сар

## **Менежментийн захидал**

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидалыг АМГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидалын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Ашигт малтмалын газрын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.Энхзаяа

АУДИТЫН МЕНЕЖЕР

Г.Гүнжидмаа

Огноо:2015.2.25

Огноо:2015.2.25

БЭЛТГЭСЭН:

ШИНЖЭЭЧ

Б.Энхжин

Огноо:2015.2.25

## АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗРЫН АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/тогтолцоо/

Дансны код	Бичавын улзулжт	Эхний улзэгээл	Эслийн улзэгээл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>520,061,202.68</b>	<b>293,741,969.13</b>
31	<b>МОНГОН ХӨРӨНГӨ</b>	234,404,939.52	20,287,916.43
31100	<b>Кассанд байгаа бэлэн монгө</b>	844,812.52	892,711.35
31120	Гадаад валют	844,812.52	892,711.35
31200	<b>Банкннд байгаа бэлэн монгө</b>	233,560,127.00	19,395,205.08
31210	<b>Төгрөг</b>	233,560,127.00	19,395,205.08
31214	Бусад төсөл, юёшний харинчах	233,560,127.00	19,395,205.08
33	<b>АВЛАГА</b>	2,683,800.00	11,000,000.00
33500	<b>Бусад авлага</b>	2,683,800.00	11,000,000.00
33510	Байгуулагаас авах авлага	683,800.00	10,000,000.00
33520	Хувь хүмүүстэс авах авлага	2,000,000.00	1,000,000.00
34	<b>УРДЧИЛГАА</b>	23,106,476.25	43,382,276.25
34600	Урдчилж гарсан зардал	23,106,476.25	23,106,476.25
34710	<b>Урьдчилгаа тооочоо</b>	-	20,275,800.00
34714	Томилжтын урьдчилгаа		20,275,800.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	259,865,986.91	219,071,776.45
35300	Балэн бүтээгдэхүүн	680,604.92	680,604.92
35400	<b>Хангамжийн материал</b>	259,185,381.99	218,391,171.53
35410	Бичиг хэргийн материал	27,554,085.16	16,221,782.67
35420	Аж ахуйн материал	198,686,033.12	187,982,349.49
35430	Сэлбог хэрэгсэл	3,850,700.01	1,922,670.01
35440	Түлш, шатах гэсэлжийн материал	25,960,823.70	9,130,629.36
35470	Бусад хангамжийн материал	3,133,740.00	3,133,740.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,190,917,503.75</b>	<b>2,548,790,021.43</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,190,917,503.75	2,548,790,021.43
39200	<b>Биет хөрөнгө</b>	3,018,532,402.86	2,422,339,100.28
39201	Барилга, байгууламж, ороу суур	1,485,521,660.00	1,485,521,660.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(157,270,386.28)	(182,582,315.20)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	727,709,904.00	727,709,904.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(443,936,094.05)	(531,528,244.73)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	3,065,797,276.66	3,019,140,569.04
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,811,892,552.05)	(2,215,563,556.42)
39207	Тавинаа, аж ахуйн эд хөгшийн	591,617,992.89	561,403,505.03
39208	Хуримтлагдсан элэгдэл	(481,666,238.45)	(482,713,221.58)
39214	Бусад үндсэн хөрөнгө	45,633,100.00	45,633,100.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,982,259.86)	(4,682,299.86)
39300	<b>Биет бус хөрөнгө</b>	172,385,100.89	126,450,921.15
39301	Програм хангамж	764,396,475.24	820,196,475.24
39302	Хуримтлагдсан элэгдэл	(592,011,374.35)	(693,745,554.09)
39400	<b>Бусад хөрөнгө</b>	-	-
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,710,978,706.43</b>	<b>2,842,531,990.56</b>
<b>4</b>	<b>НИЙТ ОР ТОЛБОР</b>	<b>236,388,597.60</b>	<b>60,023,108.78</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБОР</b>	236,388,597.60	60,023,108.78
41300	<b>Өглөг</b>	2,828,470.60	40,627,903.70
41320	Барсаа үйлчилгээний зардлын өглөг	2300,000.00	19,817,100.00
41360	<b>Бусад өглөг</b>	528,470.60	20,810,803.70
41363	Таварын өр	28,470.60	
41366	Дансны өглөг	500,000.00	20,810,803.70
41400	<b>Урьдчилж орсон өргөлө</b>	233,560,127.00	19,395,205.08
41430	Баршинаа, дэчинчилгээнд урьдчилж орсон өргөлө	233,560,127.00	19,395,205.08
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,474,590,108.83</b>	<b>2,782,508,881.78</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,474,590,108.83	2,782,508,881.78
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,377,595,106.62	4,377,595,106.62
51101	Өмч: герийн	4,377,595,106.62	4,377,595,106.62
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(960,186,861.25)	(1,652,268,088.30)
51210	Өмнөх үеийн үр дүн	(960,186,861.25)	(960,186,861.25)
51220	Тайлант үеийн үр дүн		(692,081,227.05)
51300	Хөрөнгийн дахин үзэлгээний зерүү	57,181,863.46	57,181,863.46
<b>6</b>	<b>ОР ТОЛБОР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,710,978,706.43</b>	<b>2,842,531,990.56</b>
	<b>VI=IV+V</b>		

## АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗРЫН АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Даненуу код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	/төгрөгээр/
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>48,346,937,869.73</b>	<b>53,916,723,894.41</b>	
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>45,128,267,079.24</b>	<b>50,869,864,805.90</b>	
118	Бусад татвар, төлбөр, хураамж	45,128,267,079.24	50,869,864,805.90	
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	45,128,267,079.24	50,869,864,805.90	
118002	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн телбор	43,293,647,779.24	48,449,319,569.91	
118003	Улсын төсвийн хөрөнгөөр хайтуул хийсэн ордын нөхөн төлбөр	1,834,619,300.00	2,420,545,235.99	
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>594,839,280.21</b>	<b>211,277,911.91</b>	
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>594,839,280.21</b>	<b>211,277,911.91</b>	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	278,288,485.21	3,415,456.49	
1200045	Үүс төлбөргүй хүлээн авсан орлого	278,288,485.21	3,415,456.49	
120009	Бусад орлого	316,550,795.00	207,862,455.42	
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,623,831,510.28</b>	<b>2,835,581,176.60</b>	
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,530,007,895.79</b>	<b>2,800,042,129.43</b>	
131001	Үргсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,530,007,895.79	2,800,042,129.43	
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>93,823,614.49</b>	<b>35,539,047.17</b>	
131102	Төсвийн жилийн явцад УИХ-ас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зүйл	44,141,614.49	20,648,933.69	
131103	ЗГНХ ЗДНХөрөнгө, түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хувваарилсан хөрөнгө		2,820,567.28	
131106	Төсвийн урамшуулал	49,682,000.00	12,069,546.20	
11	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>48,787,836,248.41</b>	<b>54,608,805,121.46</b>	
21	<b>ҮРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>48,787,836,248.41</b>	<b>54,608,805,121.46</b>	
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,208,026,997.07</b>	<b>3,400,195,573.44</b>	
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,751,832,463.73</b>	<b>1,750,603,866.70</b>	
210101	Үндсэн цалин	1,002,225,297.34	1,033,378,396.00	
210102	Нэмэгдэл	576,253,583.39	538,089,270.70	
210103	Унаа хоодны хөнгөлэлт	173,353,583.00	179,136,200.00	
2102	<b>Ажил олгогчоос нийтмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>195,387,761.35</b>	<b>194,843,586.70</b>	
210201	Тэтгэврийн даатгал	195,387,761.35	194,843,586.70	
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>123,798,024.30</b>	<b>19,858,431.51</b>	
210301	Гэрэл, цахилгаан	41,817,925.00	4,183,300.00	
210302	Түүлэц, халаалт	47,287,200.00	11,200,061.00	
210303	Цэвэр, бохир ус	26,872,899.30	1,270,070.51	
210304	Байрны түрээс	7,820,000.00	3,205,000.00	
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>143,806,315.59</b>	<b>149,967,919.77</b>	

210401	Бичиг хэрэг	32,015,443.15	47,250,405.03
210402	Тээвэр, шатахуун	47,123,018.46	20,419,314.32
210403	Шуудан, холбоо, ингернтийн төлбөр	29,768,763.17	38,047,601.89
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	29,816,462.34	21,036,327.51
210408	Бараа материал актальны зардал	5,082,628.47	23,214,271.02
2105	<b>Нормативт зардал</b>	400,000.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	400,000.00	
2106	<b>Эд хогшил, ургал засварын зардал</b>	60,673,283.90	18,405,140.57
210604	Ургал засвар	60,673,283.90	18,405,140.57
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	44,393,019.82	55,753,230.94
210701	Гадаад албан томилолт	11,693,478.00	11,851,641.44
210702	Дотоод албан томилолт	27,589,240.00	41,270,281.50
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,110,301.82	2,631,308.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний толбөр, хураамж</b>	111,722,948.89	459,395,073.44
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний толбөр хураамж	36,296,240.92	3,077,556.56
210803	Даатгалын үйлчилгээ	8,299,943.00	8,304,343.70
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		30,574,080.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		1,196,800.00
210813	Бусад зардал	67,126,764.97	416,242,293.18
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	776,013,179.49	751,368,323.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,766,567.00	3,832,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,060,000.00	420,285.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	772,186,612.49	747,116,038.81
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	45,579,809,251.34	51,208,609,548.02
2132	<b>Бусад ургал шилжүүлэг</b>	95,838,016.30	126,762,286.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулалт	57,457,016.00	89,678,728.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулалт		30,093,558.00
213209	Ног удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулалт	38,381,000.30	6,990,000.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	45,483,971,235.04	51,081,847,262.02
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,964,183,308.53	49,558,543,560.22
213304	Хөрөнгийн	519,787,926.51	1,523,303,701.80
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	(440,898,378.68)	(692,081,227.05)
IV	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ҮР ДҮН</b>	-	-
V	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ҮР ДҮН</b>	283,651,215.42	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	283,651,215.42	
VI	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(II)+(IV)-(V)</b>	(724,549,594.10)	(692,081,227.05)

## АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗРЫН АУДИТ ХИЙГДСЭН МОНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	/төгрөгөөр/
		Тайлант оны гүйцэтгэл	
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>49,464,853,975.07</b>	<b>54,709,752,234.72</b>
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>45,131,300,870.64</b>	<b>50,874,008,557.80</b>
118	Бусад татвар, төлбөр, хураамж	45,131,300,870.64	50,874,008,557.80
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	45,131,300,870.64	50,874,008,557.80
118002	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	43,296,681,570.64	48,453,463,321.81
118003	Улсын төсвийн хоронгөөр хайгуул хийсэн ордын нохон толбөр	1,834,619,300.00	2,420,545,235.99
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,611,548,534.25</b>	<b>809,370,335.22</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,611,548,534.25</b>	<b>809,370,335.22</b>
120009	Бусад орлого	1,229,753,093.65	629,405,118.00
120015	Даатгалын нохкорөөс хүлээн авсан мөнгө	381,795,440.60	179,965,217.22
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,722,004,570.18</b>	<b>3,026,373,341.70</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,552,310,680.00</b>	<b>2,856,027,640.00</b>
131001	Ургалт уйт ашиглаганы санхүүжилт	2,552,310,680.00	2,856,027,640.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>169,693,890.18</b>	<b>170,345,701.70</b>
131102	Гөсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлдүүлэгч зээл	120,011,890.18	155,455,588.22
131103	ЗГНХЗДНХөрөнгө түүнтгэй адилтгах ашиглалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захиргчид хуваарилсан хөрөнгө		2,820,567.28
131106	Төсвийн урамшуулал	49,682,000.00	12,069,546.20
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>49,284,859,895.98</b>	<b>54,923,869,257.81</b>
21	<b>ҮРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>49,284,859,895.98</b>	<b>54,923,869,257.81</b>
210	<b>БАГАА, АЖИЛГИЛЧИЛСЭГИИ</b>	<b>2,991,725,148.40</b>	<b>3,006,377,057.35</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,738,288,422.42	1,743,131,870.99
210101	Үндсэн цапиан	1,167,870,470.12	1,216,234,032.13
210102	Нэмэгдэл	451,211,652.30	414,697,838.86
210103	Унаа хоолны хонгөлөлт	119,206,300.00	112,200,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	193,372,195.83	191,790,573.60
210201	Тэтгэврийн даатгал	193,372,195.83	191,790,573.60
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>123,778,024.30</b>	<b>19,858,431.51</b>
210301	Гэрээ, цахигтаан	41,817,925.00	4,183,300.00
210302	Түүлц, халаалт	47,287,200.00	11,200,061.00
210303	Цэвэр, бохир ус	26,872,899.30	1,270,070.51
210304	Байрны түрээс	7,800,000.00	3,205,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	117,793,281.32	92,938,918.63
210401	Бичиг хэрэг	32,910,936.00	33,555,078.00
210402	Тээвэр, шатахуун	48,450,300.00	2,519,000.00
210403	Шуудан, холбоо, инфраструктурын төлбөр	31,352,262.92	34,645,000.53
210406	Бага үнэтэй түргэн эзлэгдэх, ахуйн эд	5,079,782.40	22,219,840.10
2105	<b>Нормативт зардал</b>	<b>3,302,800.00</b>	<b>420,000.00</b>
210501	Эм. бэлдмэл, эмизгийн хэрэгсэл	3,238,000.00	
210503	Нормын хувьис, зөвлөн эдлэл	64,800.00	420,000.00
2106	<b>Эд хогшил, ургалт засварын зардал</b>	<b>94,918,017.00</b>	<b>19,595,272.90</b>
210601	Багаж, техник хэрэгсэл	30,369,372.00	2,859,900.00
210602	Тавилга	1,560,900.00	
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,075,230.00	1,725,700.00
210604	Ургалт засвар	61,912,515.00	15,009,672.90

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>43,004,818.00</b>	<b>54,701,032.94</b>
210701	Гадаад албан томилолт	11,693,478.00	11,851,641.44
210702	Дотоод албан томилолт	27,810,640.00	41,813,081.50
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	3,500,700.00	1,036,310.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>673,403,289.53</b>	<b>879,742,956.78</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	125,278,337.54	419,072,619.15
210803	Даатгалын үйлчилгээ	8,299,943.00	8,293,343.70
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	20,700,000.00	124,416,080.00
210809	Улсын мэдээллийн магт хэвлэх, бэлтгэх	341,600.00	1,196,800.00
210817	Даатгалын төлбөрт толсон	379,341,160.29	179,490,968.42
210818	Бусад мөнгөн зарлага	139,442,248.70	147,273,145.51
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,864,300.00	4,198,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,804,300.00	3,832,000.00
210902	Хичээл үйлдвэртглийн дадлага хийх	1,060,000.00	366,000.00
<b>2112</b>	<b>ТАТААС</b>	<b>679,642,171.65</b>	<b>635,707,584.50</b>
<b>2122</b>	<b>Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас</b>	<b>679,642,171.65</b>	<b>635,707,584.50</b>
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	679,642,171.65	635,707,584.50
<b>213</b>	<b>ҮРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>45,613,492,575.93</b>	<b>51,281,784,615.96</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>106,718,556.68</b>	<b>131,789,186.01</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулалт	34,093,156.38	18,315,108.01
213205	Төрөөс иргээд олгох тэтгэмж, урамшуулалт		50,907,125.00
213207	Тэтгээрг гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,973,000.00	51,206,953.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал	49,652,400.30	11,360,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	45,506,774,019.25	51,149,995,429.95
213303	Төвлөрүүлэх ширүүүүүлэг	44,986,986,092.74	49,626,691,728.15
213304	Хөрөнгийн	519,787,926.51	1,523,303,701.80
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>179,994,079.09</b>	<b>(214,117,023.09)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>179,994,079.09</b>	<b>(214,117,023.09)</b>
<b>IX</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхийн үлдэгдэл</b>	<b>54,410,860.43</b>	<b>234,404,939.52</b>
<b>X</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>234,404,939.52</b>	<b>20,287,916.43</b>

## АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗРЫН АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГО/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үндэсний иөөн	Хуримтлагдсан дун	/ тагрөөр / Засгийн газрын хувь оржлооийн нийт дун
1	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,377,595,106.62	57,181,863.46	(229,137,101.60)	4,205,639,868.48
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,377,595,106.62	57,181,863.46	(235,637,267.15)	4,199,139,702.93
7	Тайланг үеийн үр дун			(724,549,594.10)	(724,549,594.10)
8	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,377,595,106.62	57,181,863.46	(960,186,861.25)	3,474,590,108.83
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,377,595,106.62	57,181,863.46	(960,186,861.25)	3,474,590,108.83
15	Тайланг үеийн үр дун			(692,081,227.05)	(692,081,227.05)
16	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,377,595,106.62	57,181,863.46	(1,652,268,088.30)	2,782,508,881.78

## АШИГТ МАЛГМАЛЫН ГАЗРЫН АУДИТ ХИЙГДСЭН ТОСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Хоталб орийн код	Зориулалт , арга хэмжээний код	ЭЗ Ангилал 2015	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/ төгрөгөр /	
						Зоруу	Хувь
70101	80101	I	Мөнгө, түүтийн адилтгах хөрөнгийн эхийн үзүүлэлт	-	234,404,939.00	234,404,939.00	0.00
70101	80101	II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛЛИЙН ДҮН	3,108,845,058.00	2,800,042,129.43	(308,802,928.57)	-9.93
70101	80101	21	ҮРСТАЛ ЗАРДАЛ	3,108,845,058.00	2,800,042,129.43	(308,802,928.57)	-9.93
70101	80101	210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,976,240,400.00	2,679,612,943.42	(296,627,456.58)	-9.97
70101	80101	2101	Цэлини холе болон ижмээдүйн урамшил	1,766,796,400.00	1,743,131,870.99	(23,664,529.01)	-1.34
70101	80101	210101	Үндсэн цэвэр	1,218,983,900.00	1,216,234,032.13	(2,749,867.87)	-0.23
70101	80101	210102	Нэмийдэл	379,917,400.00	374,584,603.96	(5,332,796.04)	-1.40
70101	80101	210103	Унан хоолын хөнгөнчилт	112,200,000.00	112,200,000.00	-	0.00
70101	80101	210105	Гэрээт ажлын хэлс	55,695,100.00	40,113,234.90	(15,581,865.10)	-27.98
70101	80101	2102	Ажил олгогчоос нийгмийн давтгалд төлөх шийгүүлэлт	194,347,800.00	191,790,573.60	(2,557,226.40)	-1.32
70101	80101	210201	Тэгэвэрний давтгал	124,317,408.51	122,681,641.30	(1,635,767.21)	-1.32
70101	80101	210202	Тэгэвэрийн давтгал	13,653,233.62	13,473,584.51	(179,649.11)	-1.32
70101	80101	210203	ҮОМШО-ийн давтгал	17,507,597.88	17,277,235.08	(230,364.80)	-1.32
70101	80101	210204	Ажлыгүүрийн давтгал	3,854,564.26	3,803,648.57	(50,715.69)	-1.32
70101	80101	210205	Эрүүл мэншийн давтгал	35,015,195.73	34,554,466.14	(460,729.59)	-1.32
70101	80101	2103	Байршилглалттай хөлбөстийн тогтолц зардал	43,492,100.00	19,858,431.51	(23,633,668.49)	-54.34
70101	80101	210301	Гэрээц хийгдэл	11,747,600.00	4,183,300.00	(7,564,300.00)	-64.39
70101	80101	210302	Туслын хадалыг	16,398,800.00	11,200,061.00	(5,198,739.00)	-31.70
70101	80101	210303	Цэвэр бояир ус	9,945,700.00	1,270,070.51	(8,675,629.49)	-87.23
70101	80101	210304	Баярын түргэж	5,400,000.00	3,205,000.00	(2,195,000.00)	-40.65
70101	80101	2104	Хангамж, барваа материялын зардал	107,703,700.00	92,938,918.63	(14,764,781.37)	-13.71
70101	80101	210401	Биник хэрэг	34,422,600.00	33,555,078.00	(867,522.00)	-2.52
70101	80101	210402	Тэжээр, шатахуун	3,416,200.00	2,519,000.00	(2,897,200.00)	-53.49
70101	80101	210403	Шүүдээс хөлбө, интернетийн төлбөр	35,702,500.00	34,645,000.53	(1,057,499.47)	-2.96
70101	80101	210406	Бага уягтэй түргэнээгээдэх, ахуйн эх зүйлс	32,162,400.00	22,219,840.10	(9,942,559.90)	-30.91
70101	80101	2105	Нормативт зардал	1,050,000.00	420,000.00	(630,000.00)	-60.00
70101	80101	210503	Нормын хувьцас, зөвлөн эдлээ	1,050,000.00	420,000.00	(630,000.00)	-60.00
70101	80101	2106	Эд хөгжил, угсрал засварын зардал	19,970,000.00	19,595,272.90	(374,727.10)	-1.88
70101	80101	210601	Багаж, техник, хэрэгслий	4,000,000.00	2,839,900.00	(1,140,100.00)	-28.50
70101	80101	210603	Холостимер хамгаалын хэрхүэлэ	2,370,000.00	1,725,700.00	(644,300.00)	-27.19
70101	80101	210604	Ургал засвар	13,600,000.00	15,009,672.90	1,409,672.90	10.37
70101	80101	2107	Томилолт, зочны зардал	61,859,600.00	54,701,032.94	(7,158,567.06)	-11.57
70101	80101	210701	Галавт албан томилолт	5,737,500.00	11,851,641.44	6,114,141.44	106.56
70101	80101	210702	Дотоод албан томилолт	53,782,100.00	41,813,081.50	(11,969,018.50)	-22.25
70101	80101	210703	Зочны төлөвлөгөөнүүдээс авах	2,340,000.00	1,036,310.00	(1,303,690.00)	-55.71
70101	80101	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлы, үйлчилгээний төлбөр, хураамж	770,770,800.00	552,978,842.85	(217,791,957.15)	-28.26
70101	80101	210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтийн ажлыг үйлчилгээний төлбөр хураамж	425,889,000.00	417,400,219.15	(8,488,780.85)	-1.99
70101	80101	210803	Давтагчны үйчилгээ	8,300,000.00	8,293,343.70	(6,656.30)	-0.08
70101	80101	210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,950,000.00	1,672,400.00	(277,600.00)	-14.24
70101	80101	210806	Мэдээлэл, технологийн үйчилгээ	332,381,800.00	124,416,080.00	(207,965,720.00)	-62.57
70101	80101	210809	Үзүүлийн мэдээллийн мийгж хөвчэх, балтгях	2,250,000.00	1,196,800.00	(1,053,200.00)	-46.81
70101	80101	2109	Барваа үйлчилгээний бусад зардал	10,250,000.00	4,198,000.00	(6,052,000.00)	-59.04
70101	80101	210901	Барваа үйлчилгээний бусад зардал	7,000,000.00	3,832,000.00	(3,168,000.00)	-45.26
70101	80101	210902	Хичээл үйлчилгээний дадлага хийх	3,250,000.00	366,000.00	(2,884,000.00)	-88.74
70101	80101	213	ҮРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	132,604,658.00	120,429,186.01	(12,175,471.99)	-9.18
70101	80101	2132	Бусад уграгал шилжүүлэлт	132,604,658.00	120,429,186.01	(12,175,471.99)	-9.18
70101	80101	213204	Ажил олгогчоос олох бусад тэгжмж, урамшуулалт	21,800,000.00	18,315,108.01	(3,484,891.99)	-15.99
70101	80101	213205	Төрөс ирсэлдээ олгох тэлтээмж, урамшуулалт	50,907,158.00	50,907,125.00	(33.00)	0.00
70101	80101	213207	Тэгтээвэр гарахад олгох нег удаагийн мөнгөн тэлтээмж	59,897,500.00	51,206,953.00	(8,690,547.00)	-14.51
70101	80101	IV	Мөнгө, түүтийн адилтгах хөрөнгийн эсийн үзүүлэлт	-	20,287,916.43	20,287,916.43	0.00
70101	80101	IV	Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт	-	270,102,533.66	270,102,533.66	0.00
70101	80101	6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛҮЙН	-	-	-	0.00
70101	80101	61	БАЙГУУЛАГЫН ТОО	146.00	146.00	-	0.00
70101	80101	610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	0.00
70101	80101	62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	145.00	145.00	-	0.00
70101	80101	620001	Удорах ажлын	17.00	17.00	-	0.00
70101	80101	620002	Гүйцэтгэх ажлын	116.00	116.00	-	0.00
70101	80101	620003	Үйнхүүлэх ажлын	10.00	10.00	-	0.00
70101	80101	620004	Гэрээлэх ажлын	2.00	2.00	-	0.00